



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР  
АКТ

2018 оны 02 дугаар сарын 20

№ 01/16 3 УА - 2018/15/СТА-ПЧЗ

Мандалговь хот

Г

Т

Төлбөр барагдуулах тухай

Аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Адаацаг сумын ЗДТГ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайллангийн аудитаар сахилгын шийтгэлтэй төрийн албан хаагчдад 1,080,000.00 /нэг сая мянган/ төгрөгийн урамшуулалыг олгосон зөрчил илэрлээ.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар толовлаж зарцуулах/, Төрийн албаны тухай хуулийн 26.6-д /Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойши нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно./, Улсын Их Хурлын 2017 оны 67-р тогтоолын 1.1-д /2017 оны төсвийн жилд төрийн ондөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 тогрогийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох/, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд: /Улсын Их Хурлын 2017 оны 67-р тогтоолын дагуу 2017 онд төрийн ондөр албан тушаалтан, шүүгч прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 тогрогний урамшуулал олгох тухай асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захирагч нарт даалгав/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал/ гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Урамшуулалд олгосон 1,080,000.00 /нэг сая наян мянган/ төгрөгийг холбогдох албан тушаалтаар нөхөн төлүүлж 100080000955 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор тус тус төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн шууд захирагч Б.Уранцэцэг, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт хариуцуулав.

**АКТЫГ**

<b>ТОГТООСОН<sup>1</sup>:</b>	
АУДИТОР:	ЖУГТАХБАЯР
	
4817144213 ЗЮА0039 9033475	

<b>ЗӨВШӨӨРСӨН:</b>	
ЗДТГ-ЫН ДАРГА:	Б.УРАНЦЭЦЭГ
НЯГТЛАН БОДОГЧ:	Б.ЭНХЖАРГАЛ
	
ЗАЛ0001 9033637 4815 109263	

---

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.